



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/142

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Автомашины парк засвар /аймгийн ИТХ/” ДУОНӨГ/2017/00021/13”-ийн гүйцэтгэгчээр “Загал буурал хайрхан” сэлбэгийн дэлгүүрийг сонгон 10,000,000 /арван сая/ төгрөгөөр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Автомашины парк засварын ажлыг батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Загал буурал хайрхан” сэлбэгийн дэлгүүрийн эзэн /П.Батбилэг/-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, ИТХ-ын нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0300435